



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/56

Арвайхээр сум


Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын
бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" А/825 дугаар захирамжийн хавсралтын дэсийн 15 дугаарт Нярав-үйлчлэгч "1" гэснийг Нярав "1", дэсийн 17 дугаарыг шинээр нэмж Үйлчлэгч "1", бүгд "20" гэснийг "21" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Тухайн орон тоог нэмэгдүүлэхэд шаардагдах цалингийн санг орон нутгийн төсөвт багтаан санхүүжүүлж, захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0123